



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА  
О.АЛТАНСҮХ ТАНАА

2019.02.25 № 06/304  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Аудитын гол асуудал

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давсан нь “Хязгаарлалттай санал дүгнэлт” өгөх үндэслэл болно. Үүнд:

- Удирдах ажилтны зөвлөгөөн, спортын арга хэмжээн зохион байгуулах, ахмадын өдөр тэмдэглэх, байгууллагын брендбүүк хийлгэх, ойн арга хэмжээ санхүүжүүлэх зэрэг нийт 184,889.3 мянган төгрөгийг зарцуулсан;
- Анхан шатны бүрдэл дутуу 208,009.7 мянган төгрөгийн баримтаар гүйлгээ хийж нягтлан бодох бүртгэлд тусгасан;
- Зөвлөх үйлчилгээний урьдчилгаа төлбөрт 40,000.0 мянган төгрөг төлсөн, гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгүүлээгүй;
- Бараа материалын 9,412.4 мянган төгрөгийн үлдэгдэлд жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийгээгүй;


зэрэг нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдэлүүдийг хангаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.1, 70.2.2 дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2019 оны 03 дугаар сарын 01

№ 01/46

Улаанбаатар хот

СЭГ- 2019/65/СТА-ТМЗ  
Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Тайлант онд 18 төрийн бус байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагаар гүйцэтгүүлсэн ажлын 208,009.7 мянган төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтыг үндэслэн санхүүжилтийг олгосон.
- Кино хийхэд 132,400.0 мянга, жүжиг хийлгэх, хүүхдүүдэд үзүүлэхэд зориулж 22,095.0 мянган төгрөгийг үрэлгэн зарцуулсан
- Удирдах ажилтны зөвлөгөөнд 16,856.8 мянга, спортын арга хэмжээнд 8,532.5 мянга, ахмадын өдөрт 3,500.0 мянга, байгууллагын брендбүүк хийлгэхэд 20,000.0 мянга, магистр, докторын сургалтын төлбөрт 11,000.0 мянга, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 40 жилийн ойн арга хэмжээнд 125,000.0 мянга, нийт 184,889.3 мянган төгрөгийг төсвийн зориулалт зөрчин зарцуулсан;
- Эм Эс Си Ай ХХК-тай 2018 оны 3 дугаар сарын 22-нд 51/2018 дугаартай 50,000.0 мянган төгрөгийн "Зөвлөх үйлчилгээний гэрээт ажил"-ыг 2018 оны 3 дугаар сарын 22-ноос 2018 оны 6 дугаар сарын 29-нийг хүртлэх хугацаанд гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан. Гэрээт ажлын урьдчилгаа 40,000.0 мянган төгрөг олгосон, хугацаанд нь гүйцэтгүүлээгүй байна.

Дээрх асуудлууд нь оршин байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй, нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйл 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,"; 41 дүгээр зүйлийн 41.2.3 "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах,"; 41.2.7. "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах."; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалтуудыг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

*Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*


- 4
1. Бусдаар гүйцэтгүүлж байгаа ажлын гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, санхүүжилтийг анхан шатны бүрдэл хангасан баримтыг үндэслэн олгож байх, төсвийн хөрөнгийг батлагдсан төсөв, зориулалтын дагуу зарцуулж, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх.
  2. Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга О.Алтансүх, ахлах нягтлан бодогч У.Батнасан нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

**ТОГТООСОН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  
Ц.НАРАНЧИМЭГ  
АХЛАХ АУДИТОР  
Д.ЭНХДАЛАЙ



**ЗӨВШӨӨРСӨН:**  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА  
О.АЛТАНСҮХ  
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ  
У.БАТНАСАН



Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан .....	4
2.1.	Оршил .....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
3	Менежментийн захидал .....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	19
5	Хавсралт .....	21
5.1	Аудитын явцад илрүүлсэн алдаа зөрчлийн нэгтгэл .....	21

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 76-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА  
О.АЛТАНСҮХ ТАНАА

2019.02.25 № 06/324  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.


### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.19.20\Bchig\_Kheregi\Yawsan\_Bchig\2019\2265\AG91.Docx



### Аудитын гол асуудал

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давсан нь "Хязгаарлалттай санал дүгнэлт" өгөх үндэслэл болно. Үүнд:

- Удирдах ажилтны зөвлөгөөн, спортын арга хэмжээн зохион байгуулах, ахмадын өдөр тэмдэглэх, байгууллагын брендбүүх хийлгэх, ойн арга хэмжээ санхүүжүүлэх зэрэг нийт 184,889.3 мянган төгрөгийг зарцуулсан;
- Анхан шатны бүрдэл дутуу 208,009.7 мянган төгрөгийн баримтаар гүйлгээ хийж нягтлан бодох бүртгэлд тусгасан;
- Зөвлөх үйлчилгээний урьдчилгаа төлбөрт 40,000.0 мянган төгрөг төлсөн, гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгүүлээгүй;
- Бараа материалын 9,412.4 мянган төгрөгийн үлдэгдэлд жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийгээгүй;

зэрэг нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдэлүүдийг хангаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.1, 70.2.2 дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*Ц. Наранчимэг*

Ц.НАРАНЧИМЭГ



## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга О.Алтансүх Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 27-ноос 2019 оны 2 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Энхдалай хариуцаж хэрэгжүүлэв.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндсэний аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/37 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь “Төрийн бодлогыг гэр бүлд суурилан хэрэгжүүлэх эрх зүй, тогтолцооны шинэчлэлд үнэт хувь нэмэр оруулж, гэр бүл, хүүхэд, залуучуудыг хамгаалах, хөгжүүлэх, төлөвшүүлэх үйлчилгээг сайжруулах замаар Монгол хүний хөгжил, үндэсний дархлааг бэхжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн шинэчилсэн хөтөлбөр”-т Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Үндэсний хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хүний эрхэд суурилсан хандлага, өсвөр үе, залуучуудын үзэл бодол болон гэр бүлийн хөгжлийн хэрэгцээнд нийцүүлэхэд нөлөөлж, хуулийг сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;
2. Агентлагийн болон харьяа байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, харьяа байгууллагуудын бодлого төлөвлөлтийг оновчтой тодорхойлох, хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлэх, гэр бүл, хүүхэд,

- залуучуудын хөгжил хамгаалал, зорилтот хэсэгт хүрч үйлчлэх бүтцийн болон үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, тогтвортой байдлыг хангах;
3. Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаар мэргэжил арга зүйн удирдлагаар холбогдох талуудыг хангаж, үндэсний чадавхийг бий болгох;
  4. Гэр бүл, хүүхэд, залуучуудад зориулсан бүх шатны үйлчилгээний чанар, хүртээмж, стандартыг олон улсын жишигт нийцүүлэх, нийгмийн хөгжлийн үйлчилгээг хэрэгцээнд тулгуурлан тодорхойлох, уялдаа холбоог бэхжүүлэх, үйлчилгээнд инновацийг нэвтрүүлэх;
  5. Гэр бүл, хүүхэд, залуучуудыг дэмжих, хамгаалах, хөгжүүлэхэд төр, олон нийт, иргэний нийгэм, олон улсын болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлж, хүүхэд, залуучуудын оролцоог өргөжүүлэх;
  6. Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаар судалгаа, мэдээллийн санг бүрдүүлж, хяналт, шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлж, мэдээллийн удирдлагыг хэрэгжүүлэх, мэдээллийн технологийн ололтыг салбарт нэвтрүүлэх;

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Гэр бүлийн тухай хууль;

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны Залуучуудын тухай хуулийг шинээр батлагдсан.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тооцоолох группын "Acolous" програм хангамж ашигладаг байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын санхүүгийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Тус байгууллага нь "Гэр бүлийн тогтвортой, хамтын амьдралыг дэмжих, хүүхэд, залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, чадавхижуулах, гэр бүл төвтэй хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын арга зүйг баримталж, хүн амын хөгжил, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын бодлого, үйл ажиллагааны хүрээнд нийгэмд төрийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байгааг харгалзан нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонголоо.

Үйл ажиллагааны болон, санхүүгийн тайлан, балансын дансанд хийсэн эрсдэлийн үнэлгээг харгалзан материаллаг байдлын түвшинг 2 хувиар тооцсон.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны нийт зардал 7,922,169.4 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 158,443.4 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

**2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1,148,328.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 551,522.2 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 587,394.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 9,412.4 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 9 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал


(мянган төгрөгөөр)				
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	9,412.4	
2	Албан шаардлага өгсөн	4	587,394.0	
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>596,806.4</b>	

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

**2.8.1.1 Балансын данстай холбоотой асуудал**

Тайлант онд 18 төрийн бус болон аж, ажуйн нэгж байгууллагаар гүйцэтгүүлсэн ажлын нийт 208,009.7 мянган төгрөгийн санхүүжилтийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн нь оршин байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалтыг зөрчсөн;



Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

#### 2.8.1.2 Зардлын данстай холбоотой асуудал

Кино хийхэд 132,400.0 мянга, жүжиг хийлгэх, хүүхдүүдэд үзүүлэхэд зориулж 22,095.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хууль 16 дугаар зүйл 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”* заалтыг зөрчсөн;

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

#### 2.8.1.3 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Удирдах ажилтаны зөвлөгөөнд 16,856.8 мянга, системийн спортын арга хэмжээнд 8,532.5 мянга, ахмадын өдөрт 3,500.0 мянга, Брэйнсторм ХХК-аар байгууллагын брендбүүк 20,000.0 мянган төгрөгөөр хийлгэхэд, сургалтын зардлаас магистер, докторын сургалтын төлбөрт 11,000.0 мянга, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 40 жилийн ойн арга хэмжээнд хүүхэд хамгааллын зардлаас 125,000.0 мянган төгрөгийг тус тус төсвийн зориулалт зөрчин зарцуулсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”* заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

#### 2.8.1.4 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

Эм Эс Си Ай ХХК-тай “Салбарын болон байгууллагын үйл ажиллагаанд судалгаа шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх” 50,000.0 мянган төгрөгийн ажлыг 2018 оны 3 дугаар сарын 22-ноос 2018 оны 6 дугаар сарын 29-нийг хүртлэх хугацаанд гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, урьдчилгаа төлбөрт 40,000.0 мянган төгрөг төлсөн боловч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, хүлээн аваагүй, гэрээг сунгаагүй, хариуцлагын талаар зүйл, заалт оруулаагүй нь тохиолдсон байх, үнэн зөв байдал батламж мэдэгдэлүүдтэй нийцээгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-дэх *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”,* 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь *“төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;”,* 41.2.7. дахь *“хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.”*, заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулах, дотоод хяналт, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал:

- Нөлөөлөл, сурталчилгааны материалыг их хэмжээгээр хэвлүүлж бэлтгэх нь агуулга, чанар байдал нь алдагдах, цаг үеийн шаардлагыг хангахгүй болох, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах эрсдэл үүсгэж байна.
- Нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй, хөрөнгийг данс бүртгэлд зөв ангилан бүртгээгүй зэрэг нь санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналтыг сулруулж байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

